



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 780

Улаанбаатар хот

Удирдамж болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, 21 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг удирдамж болгосугай:

1.1. “Монголын цахилгаан холбоо” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал М.Алтан-Очирыг үүрэгт ажлаас нь чөлөөлж, түүнтэй байгуулсан Хөдөлмөрийн гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу цуцлах;

1.2. Авлигатай тэмцэх газрын 2020 оны 05/14429 дугаар албан бичиг болон Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын 2020 оны 1/1244 дүгээр албан бичгээр ирүүлсэн саналыг харгалзан “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн гүйцэтгэх захирлаар Баатаржавын Чинбатыг томилох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-г даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ